



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/220

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сангийн шилжих хөрөнгө оруулалт”-аар санхүүжүүлэх Мөрөн сумын “Хүүхдийн парк”-ийн кассын байр бүхий ариун цэврийн байгууламжийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээнд үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилжих зураг төсвийн сангаас гаргаж зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН